


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2081 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 1/69

Мандалговь

Г Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг
вакцинаар дархлаажуулах ажлыг зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."а" дахь заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Коронавируст халдварт(ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 05 тоот тушаалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Ш.Төрбат

(Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Г.Наранбаатар

(Цагдаагийн газрын дарга)

Н.Баттогтох

(Тагнуулын хэлтсийн дарга)

Г.Бат-Орших

(Эрүүл мэндийн газрын дарга)

Ц.Лувсанжамц

(Онцгой комиссын нарийн бичгийн

дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Саруулцэцэг

(Эрүүл мэндийн газрын Нийгмийн
эрүүл мэндийн хэлтсийн дарга)

2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааг үндэсний төлөвлөгөөний хүрээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), дархлаажуулах арга хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллагыг татан оролцуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (Ц.Лувсанжамц), Сумдын онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн онцгой комиссыг явцын мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210179